TAKHILT KHAIRKHAN TRANS
LLC
**ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК**
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
Их Монгол Улсын гудамж,
Моннис Бьюлдинг, 6-р давхар
Утас: + (976) 90112492
Email: admin@tkt.mn

2025.02.25 № 25/026
танай____________ны №____________-т

БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН
БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Манай компани Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутаг дэвсгэрт 80.0 га бүхий талбайд 300-350 ширхэг хүнд даацын автомашины зогсоол, 1200 ажилчдыг байрлуулах кемп, дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны 02-р сарын 08-ны өдөр батлагдсан 2020/Т-180 дугаар бүхий төслийн Байгаль орчинд нөлөөллөх байдлын нарийвчилсан үнэлгээ, Дорноговь аймгийн байгаль орчны газрын 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн 107 дугаар бүхий албан бичгийн зөвлөмжүүд болон БОАЖС-ын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хүрээнд бэлтгэгдсэн 2024 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлж байна.

Холбогдох журмын дагуу биелэлтийг хянан батлаж, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Хавсралт – Тайлан 1 хувь

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ    ЛАЙ ЖЭНЬБАО

УЛААНБААТАР ХОТ
ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК
1118259925 6284655
АМТ02013

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ-ны

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН

ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК-ИЙН

ЗАХИРАЛ ЛАЙ ЖЭНЬБАО

# "ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК-ийн ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ БАЙРЛАХ "ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТОБААЗ"ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6284655 /

ХЯНАСАН:

БОУАӨЯ-ны ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН П. ШИНЭЦЭЦЭГ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК-ИЙН

ЗАХИРАЛ ЛАЙ ЖЭНЬБАО

"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК-ИЙН

БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б. ЛХАГВАЖАРГАЛ

2024 ОН

## АГУУЛГА


1. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТНЫ ТАНИЛЦУУЛГА ....4
1.1 Төслийн товч танилцуулга ....4
1.2 Төслийн ерөнхий мэдээлэл....4
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ....5
2.1 Агаар орчин хамгаалал ....5
2.1.1 Нүүрс тээвэрлэлтийн хөдөлгөөний нэгдсэн маршрут ....5
2.1.2 Хурдны хязгаарын тэмдэг байршуулалт....5
2.1.3 Тээврийн замын усалгаа арчилгаа ....5
2.1.4 Орчны эвдэрч, талхлагдсан газрыг нөхөн сэргээнэ....5
2.1.5 Цаг агаарын урьдчилсан мэдээлэл ....5
2.1.6 Нүүрс тээврийн үйл ажиллагааг маршрутын замаар явуулж, нүүрсийг хучиж тээвэрлэнэ ....6
2.1.7 Агаарын нарийн ширхэглэгт тоосны хэмжилтийн үр дүн ....7
2.1.8 Төслийн дулаан хангамжийг боловсруулалт, төлөвлөгөө ....8
2.2 Усны чанар болон нөөцийн хамгаалал....8
2.2.1 Төслийн ус ашиглуулах дүгнэлт болон захирамж, гэрээ ....8
2.2.2 Асгаралтын бүртгэл, саармагжуулалт....8
2.2.3 Худгийн байр, тохижуулалт....8
2.2.4 Бохир ус хаях цэгийг тогтоосон захирамж ....9
2.2.5 Ус цэвэршүүлэх төхөөрөмж байршуулах....9
2.2.6 Усны чанарын хяналтын биелэлт ....9
2.2.7 Худаг уст цэг гаргах зөвшөөрөл, ашиглалтын худгуудыг тоолууржуулсан байдал 10
2.2.8 Ус ашиглалт болон төлбөр барагдуулалтын байдал ....11
2.2.9 Усны төвшин хэмжилтийг улирал тутамд гүйцэтгэнэ. ....11
2.3 Хөрсөн бүрхэвчийн хамгаалал ....11
2.3.1 Тээврийн хэрэгёлийг тогтсон замтай болгож, замын тэмдэг тэмдэгжүүлэлт хийх ..11
2.3.2 Шимт хөрс хуулах, хадгалах журам боловсруулж, мөрдөн ажиллана ....11
2.3.3 Хөрсний бохирдол хяналт судалгаа....11
2.3.4 Асгаралтын сургалт журам , зөвлөмж боловсруулж танилцуулах ....12
2.3.5 Бохирдсон хөрс асгаралт саармагжуулах арга хэмжээ....15
2.4 Газрын хэвлий хамгаалал....17
2.5 Биологийн олон янз байдлыг хамгаалал....18
2.5.1 Амьтны мониторингийн үр дүн, хамгаалал ....18
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....26
3.1 Мод тарилтын тайлан ....26

**4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ... 27**
**4.1 Түүх соёлын өвийг хамгаалах сургалт, зурагт постер ... 27**
**5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 28**
**5.1 Байгаль орчны ажлын байрны үзлэгийн дүн ... 28**
**5.2 Гаалийн хяналтын талбай болон кемпийн ажилчдын хог хаягдлын сургалт ... 31**
**5.2 Уст худаг гаргах зөвшөөрлийг зохих журмын дагуу урьдчилан авна ... 31**
**5.3 Хурдны хязгаар болон мал, амьтны гарцын тэмдэг шаардлагатай цэгүүдэд байршуулна** 31
**6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 32**
**6.1 Энгийн хог хаягдлын менежмент ... 32**
**6.2 Аюултай хог хаягдлын менежмент ... 34**
**6.3 Бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээ ... 38**
**7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ... 41**
**7.1 Агаарын хяналт шинжилгээний дүн ... 41**
**7.2 Усны хяналт, шинжилгээний дүн ... 41**
**8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 47**
**9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 47**
**9.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлт ... 47**
**9.2 Ерөнхий дүгнэлт ... 48**

**ЗУРАГ**

Зураг 2. Агаарын чанарын хэмжилт, үр дүнгийн тэмдэглэл ... 7
Зураг 3. Зурагт постер байрлуулалт ... 7
Зураг 4. Цагаан зээр – Procapra gutturosa ... 18
Зураг 5. Хулан - Equus hemionus ... 19
Зураг 6. Байгаль орчны зурагт постер ... 24
Зураг 7. Мод усалгаа, арчлалт ... 27
Зураг 8. Соёлын өвийг хамгаалах тухай зурагт постер ... 27
Зураг 9. ТКТ засварын хэлтэс өөрсдөө цэвэрлэж зөрчилыг арилгасан байдал ... 30
Зураг 10. Хог хаягдлын сургалт ... 31
Зураг 11. Энгийн хог хаягдлын ангилан ялгалт ... 32
Зураг 12. Хуванцар савыг хоёрдогч түүхий эд авах газарлуу ачиж байгаа нь ... 32
Зураг 13. Аюултай хог хаягдлын ангилан ялгалт ... 34
Зураг 14. 2024.03.27-нд 7 тонн аюултай хог хаягдал ачиж тээвэрлэсэн ... 34

Зураг 15. 2024.10.06-нд 5.8 тонн аюултай хог хаягдал ачиж, тээвэрлэсэн ..............................................35
Зураг 16. 2024.12.01-нд 8.8 тонн аюултай хог хаягдалын ачиж, тээвэрлэсэн..........................................36
Зураг 17. Эмнэлгийн хог хаягдлын бүртгэл болон устгал .........................................................................37
Зураг 18. Бүх нийтийн хог цэвэрлэгээ .........................................................................................................38

# 1. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТНЫ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн товч танилцуулга

Төслийн талбай нь “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн нүүрс тээврийн авто замын 461-463 дахь километрт Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутаг дэвсгэрт 80.0 га талбайд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Төслийн хүчин чадал нь 300-350 ш хүнд даацын автомашины зогсоол, ажилчдын кемп нь 1200 ажилчдыг байршуулахаар төлөвлөсөн.

Гаалийн хяналтын талбай нийт 80 га, Ханги ажилчдын хотхон 15 га газрыг тус тус эзэлнэ.

“Гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхон, авто бааз байгуулах” төсөл нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн хилийн заагт хэрэгжинэ. Тус бүс нутгийн онцлог нь говь-цөлийн бүс нутаг бөгөөд цөлжилт эрчимтэй явагдаж буй хуурайшилт, шороон шуурга ихтэй бүс юм.

Төсөл хэрэгжих үеийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл нь орон нутгийн замаар тээвэрлэлт хийснээс агаарт тоосжилт үүсэх, нүүрс ил задгай тээвэрлэлтээс үүсэх тоосжилт үүсэх, нүүрс тээвэрлэлт болон тоосжилтоос үүссэн хөрсний бохирдол, хөрсний эвдрэл үүсэх, нүүрс бүтээсэн бүтээлгийн битүүмж алдагдах үед нүүрсний нунтаг тоосонцор агаарт тархах зэрэг бүс нутгийн эмзэг байдалд нөлөөлөх, тээврийн хэрэгслийн утаа болон техникүүдын засварын үед ажилласан тос масло хөрсөнд асгарах хөрсийг бохирдуулах, тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн дуу чимээ зэрэг байхаар байна.

## 1.2 Төслийн ерөнхий мэдээлэл

- Төсөл хэрэгжүүлэгч: Тахилт хайрхан транс ХХК
- Төслийн туслан гүйцэтгэгч: Ти Ти Си энд Ти ХХК
- Улсын бүртгэлийн дугаар: 9011730029
- Регистрийн дугаар: 6284655
- Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Их Монгол улс, Моннис бьюлдинг, 6 давхар



# 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1 Агаар орчин хамгаалал

### 2.1.1 Нүүрс тээвэрлэлтийн хөдөлгөөний нэгдсэн маршрут

Нүүрс тээврийн богино болон холын тээвэрт явах хөдөлгөөнт техникийн замын хөдөлгөөний дүрмийг гаргаж, нийт жолооч нарт зааварласан.

### 2.1.2 Хурдны хязгаарын тэмдэг байршуулалт

Нүүрс тээврийн ачиж буулгах талбай болон авто жингийн хэсгүүдэд хурдны хязгаар болон бусад үамын хөдөлгөөний анхааруулах тэмдгүүдийг байршуулж өгсөн.

### 2.1.3 Тээврийн замын усалгаа арчилгаа

Нүүрс тээврийн технологийн замын тоосжилтын төвшинг бууруулах зорилгоор өдөр болон шөнийн ээлжинд замын усалгааг тогтмол гүйцэтгэсэн бөгөөд 2024 онд нийт **3102.5 $м^3$** усыг нарийн ширхэгтэй тоосжилт дарахад ашигласан байна. Тоосжилт бууруурлах зөвлөмжийг боловсруулж Гаалийн хяналтын талбай болон ажилчдын кемпын хэлтэсүүдэд хүргүүлж ажилласан.

**Байгаль орчны удирдлагын тогтолцоо – Агаар орчны бохирдлыг бууруулах менежмент**

**Агаарын чанарыг хамгаалах, тоосжилт бууруулах усалгаа хийх зөвлөмж**

**Холбогдох хууль эрхзүй:** Агаарын тухай хууль 2012-05-17, 2-р бүлэг – 9-р зүйл

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль 2010-06-24, 7-р зүйл

**Холбогдох стандарт:** Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016

**Төслийн байршил:** Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутаг

**Төслийн бүйин онцлог:** Тус бүс нутгийн онцлог нь говь-цөлийн бүс нутаг бөгөөд цөлжилт эрчимтэй явагдаж буй хуурайшилт, шороон шуурга ихтэй бүс юм.

**Усалгаа хийх норм: 1м2** талбайд **0,08 м3** ус шаардлагатай. Үүнээс **20%** нь агаарт ууршиж, үлдсэн хувь нь хөрсөнд шингэнэ.

Хэрвээ тоосжилт дарах нэмэлт химийн бодис ашиглавал зам талбайгаас үүсэх тоосжилтыг **2** дахин бууруулах боломжтой бөгөөд хөрсний чийгийг сайн хадгалах боломжтой.

**Нэмэлт бодисын нэр, төрөл:** Dustmug, Dustblock, Глюон зэрэг болно.

**Усалгаа хийх хугацаа, давтамж:** Халуун дулааны улиралд өдөрт **2** удаа услах шаардлагатай. Ингэхдээ өглөө нар мандахаас өмнө болон орой нар жаргахын өмө усалгааг гүйцэтгэвэл хөрсний чийг харьцангуй удаан хугацаанд хадгалагдана. Мөн шөнийн ээлжинд тоосжилтын төвшин өндөр, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед усалгааг хийх шаардлагатай.

Усалгаа хийх тээврийн хэрэгслийн хурд **10-20 м/с** байвал услагаа илүү үр дүнтэй болно.

**Худгийн ундарга: 1,5-1,8 л/сек** байхад хангалттай.

### 2.1.4 Орчны эвдэрч, талхлагдсан газрыг нөхөн сэргээнэ

Орчны доройтсон 2 хэсэг газрыг **0,04 га** талбайг хааж, сэргээсэн.

### 2.1.5 Цаг агаарын урьдчилсан мэдээлэл

Нүүрс тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааг цаг агаарын нөхцөлтэй уялдуулан гүйцэтгэж

ажилласан бөгөөд шаардлагатай цаг агаарын сэрэмжтэй нөхцөлд төслийн үйл ажиллагааг тодорхой хугацаатай зогсоон ажиллалаа.

*Зураг 1. Цаг агаарын мэдээлэл*







### 2.1.6 Нүүрс тээврийн үйл ажиллагааг маршрутын замаар явуулж, нүүрсийг хучиж тээвэрлэнэ

Эрдэнэс Тавантолгойн бүлэг ордоос бүхий л тээврийн хэрэгсэл нүүрсийг хучиж, тээвэрлэж байна.

### 2.1.7 Агаарын нарийн ширхэглэгт тоосны хэмжилтийн үр дүн

Агаарын нарийн ширхэгт тоосонцорын хэмжилт, дуу чимээ, дэгдэмхий бодисын хэмжээ болон формальдгидийн хэмжээг гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхон дотор сар бүр хэмжилт хийн үр дүнг хөтөлсөн.

Талбайн агаарын чанарын хэмжилт гүйцэтгэх явцад уртын ачаа тээвэр зогссон байдалтай байсан бөгөөд богины ачаа тээврийн хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй үед гадаад орчинд агаарын мониторингийг гүйцэтгэв.

*Хүснэгт 1. Агаарын мониторингийн хэмжилтийн үр дүн дунджаар*

| Хэмжилтйн цэгийн байршил | Үзүүлэлтийн нэр | Хугацаа /мин/ | Хэмжих нэгж | Стандарт утга | Хэмжигдсэн утга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Авто пүү, нүүрс ачиж буулгах цэгийн орчимд | PM 10 | 10 мин | мкг/м$^3$ | 0-50 | 23 | Уртын болон богинын ачаа тээвэргүй үеийн хэмжилтийн үр дүн |
| | PM 2.5 | 10 мин | мкг/м$^3$ | 0-35 | 12 | |
| | Агаарын чийгшил | 10 мин | мкг/м$^3$ | 30-60 | 65 | |
| | Дуу чимээ | 10 мин | дБа | 45-60 | 52 | |
| | Салхины хурд | 10 мин | м/сек | | 2-3 | |
| | Агаарын температур | 10 мин | T$^0$ | | 25 | |
| | TVOC | 10 мин | | | 9.6 | |
| | HCHO | 10 мин | | | 0 | |

*Зураг 2. Агаарын чанарын хэмжилт, үр дүнгийн тэмдэглэл*




Агаарын бохирдол PM2.5 тоосонцор юунаас үүсдэг Эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх урьдчилан сэргийлэх зурагт хуудас хийж уурын зуух болон амрах байруудад байршуулсан.

*Зураг 3. Зурагт постер байрлуулалт*










### 2.1.8 Төслийн дулаан хангамжийг боловсруулалт, төлөвлөгөө

Боловсруулалтын шатанд явагдаж байна.

### 2.1.9 Дуу чимээний хэмжилт

Агаарын нарийн ширхэгт тоосонцорын хэмжилт, дуу чимээ, дэгдэмхий бодисын хэмжээ болон формальдгидийн хэмээг гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхон дотор сар бүр гүйцэтгэсэн бөгөөд уртын болон богины тээвэртэй, тээвэргүй үед хяналтын цэгт хэмжсэн бөгөөд нийт **80** удаагийн хэмжилтийн үр дүн бүртгэгдсэн.

## 2.2 Усны чанар болон нөөцийн хамгаалал

### 2.2.1 Төслийн ус ашиглуулах дүгнэлт болон захирамж, гэрээ

Төслийн хувьд ус ашиглалтын байдалд хууль эрхзүйн дараах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.

- БОАЖС-ын 2021 оны 7-р сарын 9-ний өдрийн 01/3144 дугаар бүхий ай савын лавлагаатай
- Дорноговь аймгийн БОАЖГ-н 2024 оны 04-р сарын 08-ны өдрийн 148 дугаартай ус ашиглах дүгнэлт
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын 2024 оны 04-р сарын 17-ны өдрийн А/58 дугаартай ус ашиглах зөвшөөрөл
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргатай байгуулсан 2024 оны 04-р сарын 17-ны өдрийн ус ашиглах гэрээ

### 2.2.2 Асгаралтын бүртгэл, саармагжуулалт

2024 онд нийт дизель түлшний асгаралт – **60 литр**, хурдны хайрцагны тос – **16 литр**, гидрийн шингэн – 18 **литр**, тосоор бохирдсон материал – **28 кг** үүссэн ба нийт гадаргын идэвхит нийллэг бүтээгдэхүүний бохирдлыг хөрс саармагжуулах талбайд хураан элс, ахуйн үнс, модны үртэс зэргээр саармагжууллаа.

### 2.2.3 Худгийн байр, тохижуулалт

Худаг стандартын шаардлага хангасан барилгатай.

### 2.2.4 Бохир ус хаях цэгийг тогтоосон захирамж

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт байрлах Ханги тээврийн ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбайд Галба-Өөш-Долоодыг говийн сав гзрын захиргааны 2023 оны 04-р сарын 05-ны 63 тоот албан бичгээр гаргуулсан. Хаягдал ус хаях цэг нь гол мөрний урсац бүрэлдэх эх, усны бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацалгүй байсан. Өдөрт дунджаар **13 тон** орчим, жилдээ нийт **4745 тон** ахуйн бохир усыг нэгдсэн саарал ус хаях цэгт хүргүүлсэн. Цаашид бохир ус цэвэрлэх байгууламж барих төсөл яригдаж байна.

### 2.2.5 Ус цэвэршүүлэх төхөөрөмж байршуулах

Судалгааны шатанд явж байгаа.

### 2.2.6 Усны чанарын хяналтын биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд усны ерөнхий болон хүнд металл, хими, нян судлалын шинжилгээг төслийн байгаль орчны алба “Земпроект” ХХК-тай хамтран гүйцэтгэсэн.

- Гаалийн хяналтын талбайн худгийн хувьд:

Ус зүйн шинжилгээ кемпийн худгийн уснаас хлор 1974.57 мг/л, натри 837.19 мг/л, магни 226.18 мг/г, кальци 140.28 мг/г хэмжээ тус бүр Монгол улсын ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын MNS0900:2018- стандартын зөвшөөрөгдөх дээд стандартаас хэтэрсэн ба эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээнд хэрэглэвэл аюултай болно. Химийн бүрэлдэхүүнээрээ: Сульфатын анги, натрийн бүлэг, 3 төрлийн давстай буюу шорвогдуу, маш хатуу ус бөгөөд зайлшгүй ундаанд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.

Ханги НАБТ-н талбайн гүний худгийн усны дээжийг “Инженер геодези” ХХК итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Усны шинжилгээний дүнг нэгтгэн байдлаар орчны хяналт шинжилгээний хэсэгт дэлгэрэнгүй танилцуулав.

- Боомтын худгийн хувьд:

2024 оны цэвэр усны шинжилгээний хариунаас дүгнэхэд Ханги төслийн талбайн ажилчдын ундны усны эх үүсвэр болох “Боомтын худаг”-ийн хариу нь Монгол Улсын MNS 0900:2018 стандартын хэмжээнд байгаа боловч энэ бүс нутгийн усны pH **7,21-8,44** байгаа үзүүлэлт нь шүлтлэг чанар өндөртэй болохыг харуулж байна.

Мөн Уран, Селен, Никель Кадми, Берелли зэрэг хүнд элементийн үзүүлэлт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү байна. Тус бүс нутгийн эрдэсжилт өндөртэй усыг хүнсэнд хэрэглэх үед биеийн ерөнхий тав тух алдагдах, ам цангах, биеийн хүчил шүлтийн тэнцвэр өөрчлөгдөх, зүрхний ажиллагаа сулрах, ходоод гэдэсний архаг зарим өвчин хурцдах зэрэг шинж тэмдгүүд илэрнэ. Мөн эмч нарын үзэж байгаагаар цусны эргэлтийн тогтолцооны өвчнүүд /ЦЭТӨ/ тухайлбал цусны даралт ихсэх, зүрхний шигдээс, атеросклероз /судас хатуурах/, хоол боловсруулах эрхтний өвчнүүд /ХБЭӨ/ тухайлбал ходоод, нарийн бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчнүүд, элэг цөсний архаг өвчин мөн бөөр шээсний замын чулуужих өвчин /БШЗЧӨ/ зэрэг нь эрдэсжилтээс шалтгаалах өвчин эмгэгт хамаардаг байна. Иймд катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглах, буцалгаж хэрэглэх нь эрүүл мэндэд чухал ач холбогдолтой.

Усны шинжилгээний дүнг нэгтгэн байдлаар орчны хяналт шинжилгээний хэсэгт дэлгэрэнгүй танилцуулав.

*Хүснэгт 2. Усны дээжний үзүүлэлт*

| Катион | 1 дм$^3$ | | | Анион | 1 дм$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Мг/л | Мг-экв/л | Мг-экв% | | Мг/л | Мг-экв/л | Мг-экв% |
| $Cl^-$ | 1974.57 | 55.62 | 89.68 | $Na^++K^+$ | 837.19 | 36.40 | 58.69 |
| $SO_4^-$ | 151.56 | 3.16 | 5.09 | $NH_4^+$ | 0.10 | 0.01 | 0.01 |
| $NO_3^-$ | 2.06 | 0.003 | 0.05 | $Ca^{2+}$ | 140.28 | 7.00 | 11.29 |
| $NO_2^-$ | 0.50 | 0.01 | 0.02 | $Mg^{2+}$ | 226.18 | 18.60 | 29.99 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 0.03 |
| $HCO_3^-$ | 195.26 | 3.20 | 5.16 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | - |
| Дүн | 2323.95 | 62.02 | 100.00 | Дүн | 2314.00 | 62.02 | 100.00 |

*Урвалын орчин pH- 8.16, булингаргүй, тунгалаг, өнгөгүй, үнэргүй MNS0900:2019-д химийн бүрэлдэхүүнээрээ Сульфатын анги, магнийн бүлэг, 3 төрлийн давсархаг буюу их эрдэсжилтэй, маш хатуу ус байв.*

*Хүснэгт 3. Усны дээжний үзүүлэлт*

| № | Ус | Нянгийн тоо | Гэдэсний савханцарын титр(E.coli) | Анаэробын (Cl.perfringens) |
|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу |
| 1 | НАБТ | 2 | Илрээгүй | Илрээгүй |

НАБТ орчмын уснаас авсан дээжийн шинжилгээгээр сульфат, натри, магни, кальцийн хэмжээ тус бүр Монгол улсын ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын MNS0900:2018-стандартын шаардлагыг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээнд хэрэглэвэл аюулгүй болно.

Химийн бүрэлдэхүүнээрээ: Сульфатын анги, натрийн бүлэг, 3 төрлийн давстай буюу шорвогдуу, маш хатуу ус бөгөөд зайлшгүй ундаанд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.

### 2.2.7 Худаг уст цэг гаргах зөвшөөрөл, ашиглалтын худгуудыг тоолууржуулсан байдал

“Гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхон” төсөлд 2024 онд шинээр худаг гаргах хүсэлтийг хүсэлт өгсөны дагуу Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны 2024 оны 05-р сарын 17-ны өдрийн 2024/04 дугаартай цооног өрөмдөх дүгнэлтийг авсан. Одоогоор тухайн худгийг гаргасан ашиглалт явагдахгүй байгаа.



### 2.2.8 Ус ашиглалт болон төлбөр барагдуулалтын байдал

Дорноговь аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2024 оны 04-р сарын 08-ны өдрийн 148 дугаартай ус ашиглах дүгнэлтэнд зааснаар “Гаалийн хяналтын талбай, ажилчдын кемп хотхон”-ны төсөлд

- Унд ахуйн хэрэгцээнд – 1825.0$м^3$
- Зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус – 3102.5$м^3$
- Ногоон байгууламжийн усалгаанд – 756.0$м^3$/жил ашиглахаар төлөвлөсөн. Усны төлбөрт нийт 674,311.5 төлөхөөр дүгнэлтэд тусгаж 690,000.0 төгрөгийг төвлөрүүлсэн.

### 2.2.9 Усны төвшин хэмжилтийг улирал тутамд гүйцэтгэнэ.

2025 онд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр болсон.

### 2.2.10 Ашиглаад дууссан худаг цооногийг сум орон нутагт хүлээлгэн өгөх

Ажилчдын кемпд байрлалтай худаг хэвийн ашиглалттай байгаа.

## 2.3 Хөрсөн бүрхэвчийн хамгаалал

### 2.3.1 Тээврийн хэрэгёлийг тогтсон замтай болгож, замын тэмдэг тэмдэгжүүлэлт хийх

Нүүрс тээврийн ачиж буулгах талбай болон авто жингийн хэсгүүдэд хурдны хязгаар болон бусад үамын хөдөлгөөний анхааруулах тэмдгүүдийг байршуулж өгсөн. **Нийт – 48 тэмдэг**

### 2.3.2 Шимт хөрс хуулах, хадгалах журам боловсруулж, мөрдөн ажиллана

Газар хөндөлт, шимт хөрс хуулалт байхгүй.

### 2.3.3 Хөрсний бохирдол хяналт судалгаа

Хөрс газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд сайр дагаад Элсэнцэр бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү уулархаг газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан

өртөмтгий сийрэг элсэн хөрс нэлээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний хүнд эльментийн бохирдол болон шимэрхэг байдлын шинжилгээг төслийн байгаль орчны алба “Земпроект” ХХК-тай хамтран гүйцэтгэсэн.

Хөрсний агрохимийн 4 дээжийг 300-500 гр, хүнд металлын 4 дээжийг 200-300 гр хэмжээтэй, эрүүл ахуйн 4 дээжийг 300-500 гр хэмжээтэй тус бүр авсан.

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн дагуух Гаалийн хяналтын талбай нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд байрлах бөгөөд цөлөрхөг хээрийн хужирлаг бор хөрстэй. Хөрсний онцлог нь хөрсний бүх давхаргад хатхаараа гялтганаж харагдах. НАБТ орчмын талбайгаас 0-20 см гүнд хөрсний дээж авахад талбайн орчимд цөлөрхөг хээрийн /ердийн/ бор хөрс тархсан. Хөрсний тархалтаар урвалын орчин нь/PH/ 8.24-9.43 ба хамгийн түгээмэл тархсан маш хүчтэй шүлтлэгийн орчинтой. Шүлтлэг хөрсүүд суурь катионуудаар (K+, Ca2+, Mg2+ and Na+) ханасан байдал өндөртэй . Ийм хөрсүүдийг уусах давсын агууламжаар нь бага зэргийн давсжилттай, цахилгаан дамжуулах чанар багтай шүлтлэг хөрс юм. Шүлтлэг хөрсүүд карбонатуудыг агуулдаг.

Качинскийн ангиллаар хөрсний механик бүрэлдэхүүний хувьд шавар, физик элс 2 харьцаагаар, 0.01мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээгээр элс, шавранцар, лаг ба дээжүүдийн ихэнх хэсэг нь элсэрхэг механик бүрэлдэхүүнтэйг илтгэх бөгөөд элсэрхэг элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нэлээд их талбай эзэлж байна.

Хөрсний үржил шимт үе давхаргын ялзмагийн агууламж 0.18-0.31%, хөдөлгөөнт кали 12-26 мг/100гр, хөдөлгөөнт фосфор 0.4-1.3мг/100гр байгаа нь хөрсний үржил шимийн түвшин бага байгааг илтгэх бөгөөд карбонатын (CaCO3%) агууламж 0.05-0.11 %, уусан хүчилтөрөгч (pH) 8.24-9.43 хөрсний үржил шимийн түвшин говийн хөрсөндөөдунд зэргийн үзүүлэлт боловч хялбар уусах давсны агууламж өндөр, шүлтлэг урвалын орчинтой учир ургамалд хаалт үүсгэх гол шалтгаан юм.

### 2.3.4 Асгаралтын сургалт журам , зөвлөмж боловсруулж танилцуулах

Гаалийн хяналтын талбай, ажилчдын кемп хотхоны төслийн талбайн байгаль орчны ажлын байрны үзлэгээр тос тослох материалын асгаралтын зөрчил үүссэн байсан. Үүний дагуу асгаралт зөвлөмж, журам боловсруулж хэлтэс тус бүрт хүргүүлэн ажилласан.

Environmental management system – Environmental Internal assurance & control

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ**

- Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгалах, сав бүрт хогийн тэмдэглэгээг хийх.




- Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацаа тэмдэглэсэн байна.
- Хаягдал тос масло болон тосны шүүр хуримтлуулж эхэлсэн хугацаа, хэмжээ, нэр төрөл бүрээр бүртгэлийг тогтмол хийн байгаль орчны багт сар сараар мэдээллэх.
- Хаягдал аккумулятор хуримтлуулж эхэлсэн хугацаа, хэмжээ, нэр төрөл бүрээр бүртгэлийг тогтмол хийн байгаль орчны багт сар сараар мэдээллэх.
- Хаягдал төмөр хуримтлуулж эхэлсэн хугацаа, хэмжээ, нэр төрөл бүрээр бүртгэлийг тогтмол хийн байгаль орчны багт сар сараар мэдээллэх.
- Хаягдал тос масло хадгалах савны доор хөрсөнд шингэдгүй, нэвтэрдэггүй геомембран материал дэвсэх
- Хаягдал тос маслоор бохирдсон хөрсийг саармагжуулах талбайг хийж тэмдэгжүүлэх, үер ус орхооргүй хамгаалалт хийх. Хөрс саармагжуулах талбайг хийхдээ геомембран материалыг ашиглаж битүү дэвсэх.

*Хүснэгт 4. Хэрэгжүүлэх арга хэмжээ*

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах эзэн | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэх төсөв |
|---|---|---|---|---|
| 1 | Энгийн болон аюултай хог хаягдлын журамыг нийт ажилчдад танилцуулах | ТКТ – ХАБ, Засварын хэлтэс | 2024-08-21 | |
| 2 | Энгийн болон аюултай хог хаягдлын зөвлөмжинд тусгасан ажлуудыг хэрэгжүүлж ажиллах | ТКТ – ХАБ, Засварын хэлтэс | 2024-08-21 | |
| 3 | НАБТ-н талбайн ойр орчим, эргэн тойрны хогийг тогтмол хуваарь гарган цэвэрлэх | ТКТ – ХАБ, Засварын хэлтэс | 2024-08-21 | |
| 4 | Асгаралт үүсэхээс сэргийлж аюултай хог хаягдлыг бетонжуулсан талбайд ангилан хадгалах, бүрэн хашаажуулах | ТКТ – Засварын хэлтэс | 2024-08-21 | ТКТ – Засварын хэлтсийн үйл ажиллагааны төсөв |
| 5 | Хог хаягдлын нэр, пайз байрлуулах | | 2024-08-21 | |
| 6 | Хөрсний бохирдол, асгаралтыг цэвэрлэж бохирдсон хөрс саармагжуулах талбайд хадгалах | | 2024-08-21 | |
| 7 | Аюултай хог хаягдлыг (Ашигласан тос масло, аккумлятор, тостой, тосгүй төмрийн хаягдал) эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч, баримтжуулах | | 2024-09-30 | |
| 8 | Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгсөн баримтыг байгаль орчны багт мэдээллэх | | 2024-08-21 | |
| 9 | Бохирдсон арчих, тослох материалыг тусад нь ангилан хадгалах | | 2024-08-21 | |
| 10 | Бохирдсон даавуу, тослох материалыг шатаадаг зориулалтын зуухтай болох | | 2024-08-21 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | Засварын сендвич барилгын шаланд нэмэлт лист тавих | | 2024-08-21 | |
| 12 | Аюултай хог хаягдлын бүртгэлийг хийх | | 2024-08-21 | |
| 13 | Аюултай хог хаягдлын бүртгэлийг байгаль орчны багт мэдээллэх | | 2024-08-21 | |
| 14 | Асгаралтын бүртгэл хийх | | 2024-08-21 | |
| 15 | Асгаралтын бүртгэлийг байгаль орчны багт мэдээллэх | | 2024-08-21 | |
| 16 | Тос маслоор бохирдсон хөрс, асгаралтыг цэвэрлэж бохирдсон хөрс саармагжуулах талбайд хадгалах | | 2024-08-21 | |
| 17 | Бохирдсон хөрсийг саармагжуулах талбайг боловсруулсан зөвлөмжийн дагуу шинээр байгуулах хаягжуулах | ТКТ – Барилгын хэлтэс | 2024-08-21 | |
| 18 | Түрээсийн техник ажиллуулдаг компаниудад хяналт тавих зөрчил үүссэн тохиолдолд, зөрчилийг арилгуулах | ТКТ- Байгаль орчны баг | 2024-09-01 | |

### 2.3.5 Бохирдсон хөрс асгаралт саармагжуулах арга хэмжээ

Гаалийн хяналтын талбай, ажилчдын кемп хотхоны төслийн талбайн байгаль орчны ажлын байрны үзлэгээр тос тослох материалын асгаралтын зөрчил үүссэн байсан. Үүний дагуу асгаралтыг саармагжуулах зөвлөмж, журам боловсруулж хэлтэс тус бүрт хүргүүлэн ажилласан.

**Environmental management system – Environmental Internal assurance & control**





- Засвар үйлчилгээний явцад хөрсөнд тос масло асгарсан үед элс, шороо асгаж тос асгарсан хэсгийг хусаж аван тусд нь хадгалах саванд хадгалж дараа нь тос маслоор бохирдсон хөрс саармагжуулах талбайд асгаж саармагжуулах
- Засварын талбай болон автомашин, техникийн зогсоол дээр хөрсөнд тос, масло асгарсан үед бохирдсон хөрсийг хусаж аван хөрс саармагжуулах талбайд асгаж саармагжуулах
- Аюултай хог хаягдлыг (Ашигласан тос масло, аккумлятор, тостой, тосгүй төмрийн хаягдал) эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх, хүлээлгэн өгсөн баримтыг байгаль орчны багт мэдээллэх
- Бохирдсон даавуу, ажлын бээлий, ажлын хувцас коврол, тослох материалыг ангилан ялган цуглуулах, тостой материал шатаадаг зориулалтын зуухтай болох
- Түрээсийн техник ажиллуулдаг компаниудад хяналт тавих хаягдал тос масло хөрсөнд асгах, хаях ангилан ялгаагүй зөрчил үүссэн тохиолдолд байгаль орчны багт мэдээллэх.

### 2.3.6 Ахуйн хог хаягдлаар хөрс бохирдохоос сэргийлэх арга хэмжээ

Гаалийн хяналтын талбай, ажилчдын кемп хотхоны төслийн талбайн байгаль орчны ажлын байрны үзлэгээр ахуйн хог хаягдал тархах зөрчил үүссэн байсан. Үүний дагуу ахуйн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх зөвлөмж, журам боловсруулж хэлтэс тус бүрт хүргүүлэн ажилласан.

Environmental management system – Environmental Internal assurance & control

**ЭНГИЙН БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ЗӨВЛӨМЖ**

**Энгийн болон аюултай хог хаягдлын тухай хуулийн 10.2.5 заасны дагуу дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.**

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ**

- Энгийн хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг ажлын байрны гадна бүр байрлуулж тэмдэг тэмдэглэгээг хийх.




- Дахин боловсруулах боломжтой хуванцар сав, шил, лааз зэргийг цуглуулж хоёрдогч түүхий эд авдаг газар тушаан баримтыг байгаль орчны багт мэдээллэх
- Хуванцар сав болон лаазыг нягтаршуулж боох төхөөрөмжийг ашиглах.



- Хүнсний болон бусад хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт нийлүүлэх.
- Ойр орчимын хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол хуваарь гарган хийх.

### 2.3.7 Нийтийн бие засах газрыг стандартын дагуу байгуулсан байдал, зөвлөмж боловсруулж танилцуулах

Гаалийн хяналтын талбай, ажилчдын кемп хотхоны төслийн талбайн байгаль орчны ажлын байрны үзлэгээр стандартын дагуу доторлоогүй хөрсөнд бохир шингэхээр нүхэн жорлонтой байсан зөрчил үүссэн байсан. Үүний дагуу нүхэн жорлонг буулгаж булах, ариутгах хөрсөнд бохир шингэхээргүй доторлогоотой био жорлон хийх зөвлөмж, журам боловсруулж хэлтэс тус бүрт хүргүүлэн ажилласан.

**Нүхэн жорлон, бохирын цооногт халдваргүйжүүлэлт хийх зөвлөмж**

| № | Зөвлөмж | Зураг |
|---|---|---|
| | Бодисын зааврыг сайтар унших, зааврын дагуу хэрэглэх. | |
| 2 | Хуучин ба одоо ашиглаж байгаа нүхэн жорлонгийн нүхийг ариутган халваргүйжүүлэх био ариутгагч хэрэглэх. |  |
| 3 | Хамгаалах өмсгөл, амны хаалт, бээлий нүдний шил зүүх |  |
| 4 | Санамсаргүйгээр бодис нүдрүү орвол бүлээн усаар сайтар угаах | |
| 5 | Амьсгалын замаар орвол цэвэр агаарт гарах | |
| 6 | Нүхэн жорлонг дулааны улиралд сард нэг удаа ариутгах | |
| 7 | Хуучин болон одоо ашиглаж байгаа нүхэн жорлонд үерийн ус орох, ялгадас, угаадас хальж урсахаас сэргийлж нүхний амсрыг тойруулан өргөнөөр 500 мм, зузаанаараа 50 мм-ээс багагүй налуу цементэн зуурмагаар бетондож хаяавч хийх эсвэл блок, тоосго, чулуу болон шороогоор хаяавч хийх. | |
| 8 | Хуучин нүхэн жорлонгийн нүхийг 5-10 мм хэмжээтэй 10-30 см хайрга дэвсэж нягтаршуулах, суулт өгөх бүрт нэмж хайрга дэвсэх. | |
| 9 | ГХБ-ийн талбайд ашиглагддаг нүхэн жорлон, угаадасны нүхийг "нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага"-д (MNS 5924:2015) нийцүүлэх. | |



## 2.4 Газрын хэвлий хамгаалал

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүхий хэсгийн газрууд холбогдох зөвшөөрлийн хүрээнд зориулалтын дагуу ашиглагдаж байна. Холбогдох төлбөрүүд Хатанбулаг сумын татварын

албанд төлөгдөж байна. Аливаа төслийн бүтээн байгуулалтын үед шинээр газар хөндөхөөр бол байгаль орчны багаас урдчилан зөвшөөрөл авна.

## 2.5 Биологийн олон янз байдлыг хамгаалал

### 2.5.1 Амьтны мониторингийн үр дүн, хамгаалал

Амьтны мониторинг судалгааг сар бүр ажилчдын хотхон болон гаалийн хяналтын талбайд, ойр орчимын 30 км радиуст, уст цэгт хийж дараах амьтдын төрөл зүйл бүртгэгдсэн.

*Хүснэгт 5. Бүртгэгдсэн амьтад төрөл, зүйл*

| № | Бүртгэгдсэн амьтад | Латин нэр | Тоо толгой, бодгаль |
|---|---|---|---|
| 1 | Цагаан зээр | Procapra gutturosa - Mongolian gazelle | 16 |
| 2 | Хулан | Equus hemionus | 24< |
| 3 | Хондон ангир | Tadorna ferruginea | 7 |
| 4 | Хун | Cygnus olor | 4 |
| 5 | Зэрлэг нугас | Anas platyrhynchos | 8 |
| 6 | Үнэг | Vulpes vulpes | 1 |
| 7 | Бор туулай | Lepus | 1 |
| 8 | Хонин гүрвэл | | 14 |
| 9 | Алагдаахай | | 12 |
| 10 | Дэлдэн зараа | | 1 |
| 11 | Талын жиргэмэл шувуу | | 16 |
| 12 | Хон хэрээ | | 3 |

*Зураг 4. Цагаан зээр – Procapra gutturosa*



*Зураг 5. Хулан - Equus hemionus*



### 2.5.2 Ургамлын мониторингийн үр дүн

Ургамлын монитоинг судалгааг улирал тутамд ажилчдын хотхон болон гаалийн хяналтын талбайд гүйцэтгэсэн бөгөөд дараах төрлийн ургамлууд бүртгэгдсэн.

*Хүснэгт 6. Бүртгэгдсэн ургамал*

| № | Зүйлийн нэр | | Ургамал хамгааллын статус | Зураг |
|---|---|---|---|---|
| | Латин | Монгол | | |
| 1 | ALLIUM POLYRHIZUM | Таана | |  |
| 2 | ALLIUM MONGOLICUM | Хөмөл | |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **3** | STIPA GLAREOSA | **Говийн хялгана** | |  |
| **4** | CLEISTOGENES SQUARROSA | **Дэрвээн хазаар өвс** | |  |
| | | **Зүүнгарын хазаар өвс** | | |
| **5** | ZYGOPHYLLUM XANTHOHYON | **Кашгар хотир** | |  |
| **6** | SALSOLA PASSEINA | **Бор бударгана** | |  |
| **7** | REAUMURIA SOONGORICA | **Улаан бударгана** | |  |
| **8** | CARAGANA LEUCOPHLOEA | **Алтан харгана** | |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **9** | | **Бунгийн харгана** | |  |
| **10** | | **Улаан харгана** | |  |
| **11** | PEGANUM NIGELLASTUM BGE | **Харлаг үмхий өвс** | |  |
| **12** | RHEUM NANUM | **Намхан гишүүнэ, Бажууна** | |  |
| **13** | ANABASIS BREVIFOLIA | **Ахар навчит баглуур** | |  |
| **14** | ARTEMISIA XEROPHYTICA | **Шаваг** | |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **15** | ZYGOPHYLLUM POTANINIA | **Потанины Хотир, Хулангийн ундаа** | |  |
| **16** | CONVOLVULUS AMMANNII | **Аммоны сэдэргэнэ** | |  |
| **17** | LAGOCHILUS ILICIFOLIUS | **Ямаан ангалзуур** | |  |
| **18** | PANZERINA LANATA | **Үсхий нохойн хэл** | |  |
| **19** | ASTERACEAE. TUGARINOVIA MONGOLICA ILJIN | **Монгол шар далан** | |  |
| **20** | OLGAEA LEUCOPHYLLA (TURCZ.) ILJIN | **Цагаан навчит хонгорзул** | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Будан манан хамхаг** | |  |
| 21 | | **Цагаан лууль** | |  |
| 22 | | **Имт гичгэнэ** | |  |
| 23 | CHLORIS VIRGATA SW | **Саваан булган сүүл** | |  |
| 24 | | **Гейманы бөөндий** | | |
| | | **Бага хургалж** | |  |
| 25 | SPLENDENS (TRIN.) NEVSKI. | **Гялгар дэрс** | |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **26** | | **Ямаан шарилж** | | |  |
| **27** | | **Монгол азар** | |  | |
| **31** | | **Зэл зангуу** | | |  |

Байгалийн ургамлын тухай хуулийн 15.2, 16.1, 17.3 хэсэгт дэлгэрэнгүй заасанчлан байгалийн ховор, нэн ховор ургамлыг зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэхийг хориглох тухай заалтыг төслийн талбайд ажиллаж буй ажилчдад танилцуулан, холбогдох зурагт постерийг хэвлэн, шаардлагатай газруудад 2024 онд нэмж байршуулсан.

*Зураг 6. Байгаль орчны зурагт постер*


Forbidden to collect natural rare status and endemic plants without relevant permit.
Keep wildlife Wild


Rare and extremely rare plants that may be disturbed along the paved road "TAVAN TOLGOI - MANLAI - HANGI"
Keep wildlife Wild


NO HUNTING
Illegal hunting, trapping, selling and buying of parts of wild animals is prohibited.
Keep wildlife Wild


Do not feed wildlife animals
Keep wildlife Wild

## 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 3.1 Мод тарилтын тайлан

Төслийн талбай нь “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн нүүрс тээврийн авто замын 461-463 дахь километрт Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутаг дэвсгэрт **80.0 га** бүхий талбай юм. Гаалийн хяналтын талбай нь нүүрс тээвэр, ачилт буулгалтаас үүдсэн ургамлын масс, ногоон байгууламжийн талбай багасах шалтгаан болж байна.

Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөнд орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх ажлыг жил бүр тогтмол тусган, оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

“Тахилт хайрхан транс ХХК-ийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутагт байрлах “гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхон, автобааз төсөл”-ийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, Монгол улсын ерөнхийлөгчийн 63-р тоот зарлиг, Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэр бум мод”үндэсний хөдөлгөөний дагуу мод тарих ажлыг хийж гүйцэтгэв.

Ханги ажилчдын кемпд 2024.10.13-ний өдөр нийт 31 ширхэг Хайлаас тарьсан.

| | |
|---|---|
| <br>Өтөг бууц бэлдэх явц | <br>Мод тарьж буй байдал |
| <br>Тарьж усалсаны дараа | <br>Тарисан модоо дугаарлаж хаягжуулав |

Ханги төслийн талбайн модыг төлөвлөгөөт хуваарийн дагуу бордоотой болон услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.

*Зураг 7. Мод усалгаа, арчлалт*





## 4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

### 4.1 Түүх соёлын өвийг хамгаалах сургалт, зурагт постер

“Тахилт хайрхан транс” ХХК-ийн байгаль орчны албанаас түүх соёлын өвийг хамгаалах ажлыг сурталчлан таниулах, соёлын биет өв олдвол ажлаа зогсоож, байгаль орчны багт мэдээллийг хүргэх, авран хамгаалах зэрэг ажлыг нийт гэрээлэгчдэд танилцуулсан.

*Зураг 8. Соёлын өвийг хамгаалах тухай зурагт постер*



## 5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 5.1 Байгаль орчны ажлын байрны үзлэгийн дүн

Байгаль орчны багийн дотоод ажлын байрны үзлэгийг 2024 оны 5-р сараас эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд Гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхоны дотоод болон гадаад орчинд нийт **8 удаа** хийж гүйцэтгэсэн. Үзлэгээр байгаль орчны ижил төрлийн нийт **8** зөрчил, дутагдлыг илрүүлж холбогдох хэсгийн удирдах ажилтанд илгээж, сайжруулалтуудыг гүйцэтгүүлэн ажилласан.

*Хүснэгт 7. Ажлын байрны үзлэгийн үр дүн.*

| № | Аюултай хог хаягдлын төрөл | Ангилан ялгалт | Түр хадгалалт | Зураг | Холбогдох хууль эрхзүй |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ашиглаcан тос масло, гидрийн шингэн | Ангилан ялгалт хийгдсэн | Контейнер агуулахад түр хадгалж байна. |  | Хог хаягдлын тухай хууль (2012-05-17) 10.2.5 -р зүйл заалт |
| 2 | Тосгүй хаягдал төмөр, агаар шүүгч | Ангилан ялгалт хийгдсэн | Бетон суурьгүй гадаргууд хадгалагдаж байна. |  | Хог хаягдлын тухай хууль (2012-05-17) 10.2.5 -р зүйл заалт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Тостой хаягдал төмөр, тосны шүүр | Ангилан ялгалт хийгдсэн | Контейнер дотор поошигнд ангилан түр хадгалж байна. |  | Хог хаягдлын тухай хууль (2012-05-17) 10.2.5 -р зүйл заалт |
| 3 | Хаягдал аккумлятор | Ангилан ялгалт хийгдсэн | Контейнер агуулахад түр хадгалж байна. |  | Хог хаягдлын тухай хууль (2012-05-17) 10.2.5 -р зүйл заалт |
| 4 | Тос, маслоор бохирдсон хөрс | Ангилан ялгалт хийгдсэн | Бохирдсон хөрсийг сул пошкинд хадгалж дүүрэнгүүт, тос маслоор бохирдсон хөрсийг саармагжуулах талбайд хадгалж байна. |  | Хог хаягдлын тухай хууль (2012-05-17) 10.2.5 -р зүйл заалт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Тос, масло арчих бохирдсон материал | Ангилан ялгалт хийгдсэн | Бохирдсон арчих тослох материалыг сул пошкинд болон ангилан ялгах хогийн саванд хадгалж байна. |  | Хог хаягдлын тухай хууль (2012-05-17) 10.2.5 -р зүйл заалт |
| 6 | Ус ундааны хуванцар сав, шил | Ангилан ялгалт хийгдсэн | Ус ундааны хуванцар сав, шилийг ялган ангилж тусд нь хадгалж байна. | | Хог хаягдлын тухай хууль (2012-05-17) 10.2 -р зүйл заалт |

Гаалийн хяналтын талбайд тусдаа түрээсийн техникүүд ажиллуулдаг хүмүүс, туслан компаниуд засвар үйлчилгээ хийхдээ тухайн техник түрээслэгч компани өөрсдийн гэсэн хаягдал тос, масло болон аюултай хог хаягдал хадгалах агуулах ба хамгаалалтын торон хашаатай болох шаардлагийг хүргүүлсэн. Тос масло аюултай хог хаягдал агуулах цуглуулах талбай байхгүйн улмаас дур мэдэн тос масло асгах зөрчил илэрсэн.

*Зураг 9. ТКТ засварын хэлтэс өөрсдөө цэвэрлэж зөрчилыг арилгасан байдал*



## 5.2 Гаалийн хяналтын талбай болон кемпийн ажилчдын хог хаягдлын сургалт

Гаалийн хяналтын талбайн болон кемпийн ажилчид, сайтын нүүрс тээврийн 22 жолоочид 2024 оны 09 сарын 01 нд “Таны бидний хаясан хог хаягдал байгальд хэдий хугацаанд задардаг вэ? ” сэдвийн доор сургалт хийсэн.

*Зураг 10. Хог хаягдлын сургалт*





"TTC&T" LLC - HSE FORM
TRAINING ATTENDANCE FORM
СУРГАЛТЫН БҮРТГЭЛИЙН МАЯГТ
TRAINING TOPIC:
Instructor Name
Date of Training: 2024.09.01
Training started at:
Training ended at:

### 5.2 Уст худаг гаргах зөвшөөрлийг зохих журмын дагуу урьдчилан авна

“Гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхон” төсөлд 2024 онд шинээр худаг гаргах хүсэлтийг хүсэлт өгсөны дагуу Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны 2024 оны 05-р сарын 17-ны өдрийн 2024/04 дугаартай цооног өрөмдөх дүгнэлтийг авсан. Одоогоор тухайн худгийг гаргасан ашиглалт явагдахгүй байгаа.

### 5.3 Хурдны хязгаар болон мал, амьтны гарцын тэмдэг шаардлагатай цэгүүдэд байршуулна

Нийт **4 тэмдэг** төслийн талбайд байршуулсан.

## 6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 6.1 Энгийн хог хаягдлын менежмент

Гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхон энгийн хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгадаг.

Үүнд:

- Ахуйн хатуу хог хаягдал
- Хуванцар хог хаягдал
- Барилгын хог хаягдал
- Хоолны хог хаягдал
- Ахуйн үнс
- Ахуйн шингэн хаягдал
- Бусад зэргээр ангилан ялгадаг.

*Зураг 11. Энгийн хог хаягдлын ангилан ялгалт*





2024.12.14 ний өдөр ууталсан хуванцар савыг Дорноговь аймгийн хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэрт DEOWOO 37-23 ДГА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд 1тн даацтай 10 уутыг хүргүүлсэн.

*Зураг 12. Хуванцар савыг хоёрдогч түүхий эд авах газарлуу ачиж байгаа нь*













- Ахуйн болон бусад хог хаягдлыг Заагийн хог хаягдлын цэгт төвлөрүүлсэн.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргатай байгуулсан 2024 оны 03 сарын 05 ны өдөр байгуулсан Хог хаягдал гаргасан жилийн төлбөр хураамж 600000 /зургаан зуун мянган/төгрөг 2241201428552 тоот төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргатай байгуулсан 2024 оны 04 сарын 17 ны өдөр байгуулсан Ус ашиглах гэрээний дагуу 674311 /зургаан зуун далан дөрвөн мянга, гурван зуун арван нэгэн төгрөг/ төрийн санд төвлөрүүлсэн.






### 6.2 Аюултай хог хаягдлын менежмент

Аюултай хог хаягдал үүсгэгчээр албан ёсоор бүртгэгдсэн бөгөөд бүртгэлийн дугаар **001843**. Төслийн хэмжээнд үүсэж буй аюултай хог хаягдлуудыг ангилан ялгах, бүртгэх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлж ажилласан.

*Зураг 13. Аюултай хог хаягдлын ангилан ялгалт*




Гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхоны төслийн талбайгаас нийт 3 удаа ажилласан хаягдал тос масло, тосол – **21.6 тонныг** аюултай хог хаягдал боловсруулдаг аж ахуй нэгж байгууллагад тушаасан.

*Зураг 14. 2024.03.27-нд 7 тонн аюултай хог хаягдал ачиж тээвэрлэсэн*



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 2-р сарын 2-ны өдрийн A/21 дүгээр тушаалын
1-р хавсралт

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ**

Дагалдах бичгийн дугаар:

(шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэ)

1. **Үүсгэгчийн талаарх мэдээлэл:**

Бүртгэлийн дугаар: Ү - 001843

Нэр: Тахилт хайрхан транс ХХК - 6284655

2. **Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

Овог нэр: (дармал үсгээр бичих) Н.Нямсүрэн | Гарын үсэг: (тамга) [illegible] | Он сар өдөр: 2024.03.27

3. **Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**

3.1. Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 85-10 УАХ

3.2. Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: ...

3.3. Тээвэрлэгч аж ахуй нэгжийн нэр: Хай Би Ойл ХХК

4. **Хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| № | Аюултай хог хаягдлын нэр: | Аюулын ангилал: | Савлагааны бүлэг | Савны | | Хэмжээ | Нэгж (Кг/Литр) | Аюултай хог хаягдлын ангиллын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дугаар | Төрөл | | | |
| 1 | Ашигласан тос масло | | Битүүмжилсэн төмөр торх | Битүүмжилсэн төмөр торх – 200 литр | | 6000 / 11000 | Литр | 130205 |

5. **Тээвэрлэх үед мөрдөх нэмэлт зааварчилгаа:**

- Тээвэрлэлтийн явцад аюултай хог хаягдал урсаж, асгарч, алдагдахгүй байхаар хөдөлгөөнгүй, жигд тархалттайгаар байрлуулж тээвэрлэх, том овортой сав, баглаа боодолтой аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлтэй бат бөх бэхлэх, шингэн бодисын хувьд савлагааны дүүргэлтийг хязгаарлах, тойрох үед тэнцвэр нь хадгалагдаж байхаар тохируулах, аюултай хог хаягдалтай савны амыг дээш харуулж байрлуулах
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэхэд дараах шаардлагыг мөрдөнө:

Авто тээврийн хэрэгслээр зөвхөн өдрийн цагаар тээвэрлэх, авто тээврийн хэрэгслийн хурдыг 50 км/цаг-аас хэтрүүлэхгүй байх, цуваагаар явах тохиолдолд тээврийн хэрэгсэл хоорондын зайг хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын



нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан уулын замд 300 метрээс багагүй, бусад замд 50 метрээс багагүй байхаар хурдыг сонгож явах

- Аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлагын стандартыг хангасан, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхтэй, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна. Тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийг аюултай хог хаягдал асгарах, алдагдах үед ашиглах багаж хэрэгсэл, материалаар хангах бөгөөд тээврийн хэрэгслийн жолооч нь тэдгээрийг ашиглах сургалтад хамрагдаж, зохих дадал эзэмшсэн байна. Тээвэрлэлтийн үед аюултай хог хаягдал асгарах, алдагдах тохиолдолд тээвэрлэгч нь дараах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авна, үүсгэгчид яаралтай мэдэгдэж, холбогдох зааварчилгааг авах, тухайн орон нутгийн онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж дараах мэдээллийг өгөх, аюул осол болсон газрын байршил, огноо, цаг хугацаа, аюулд өртсөн хог хаягдлын төрөл, тоо хэмжээ, үүсч болзошгүй аюултай нөхцөл байдал болон үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, шаардагдах материал болон түүний хэмжээ. Тээвэрлэгч нь аюултай хог хаягдал асгарсан, алдагдсан талаарх мэдээллийг 30 хоногийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.

6. **Аюултай хог хаягдал хүлээн авсан тээвэрлэгч:**

Овог нэр: (дармал үсгээр бичих) [illegible] | Гарын үсэг: (тамга) ХГ86041571 | Он сар өдөр: 2024.05.27

Овог нэр: (дармал үсгээр бичих) ... | Гарын үсэг: (тамга) 99101778 | Он сар өдөр: ...

7. **Үл зохицол:**

Хаягдал тосыг төмөр торхонд савласан бөгөөд төмөр чингэлэгт ачиж тээвэрлэнэ. Үл зохицол бараа материал байхгүй.

8. **Аюултай хог хаягдал хүлээн авагчийн талаарх мэдээлэл:**

Аж ахуй нэгжийн нэр: Хай Би Ойл ХХК

Бүртгэлийн дугаар: ...

Аюултай хог хаягдал хүлээн авсан:

Овог нэр: (дармал үсгээр бичих) ... | Гарын үсэг: (тамга) ... | Он сар өдөр: ...

Овог нэр: (дармал үсгээр бичих) ... | Гарын үсэг: (тамга) ... | Он сар өдөр: ...






*Зураг 15. 2024.10.06-нд 5.8 тонн аюултай хог хаягдал ачиж, тээвэрлэсэн*




*Зураг 16. 2024.12.01-нд 8.8 тонн аюултай хог хаягдалын ачиж, тээвэрлэсэн*




Гаалийн хяналтын талбай болон ажилчдын кемпийн төслийн эмч нарын хамт нийт эмнэлгийн хог хаягдлыг бүртгэлийг хөтөлж нийт 8 удаа шатааж устгасан.

*Зураг 17. Эмнэлгийн хог хаягдлын бүртгэл болон устгал*






### 6.3 Бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээ

Ханги хилийн бүсийн Ханги сайтын Гаалийн албанаас 2024 оны 08 сарын 18 ны өдөр зохион байгуулсан бүх нийтийн хог цэвэрлэгээнд ТТСТ ХХК-ийн тээврийн хэлтэс ХЭМАББО хэлтэс тээврийн жолоочид нийт 40 хүн Монгол улсын хилээс Хятад улсын хил хүртэл цэвэрлэж, Bongo3 авто машинаар 3 нь удаа тээвэрлэлт хийж дунджаар 1.5тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлсэн.

*Зураг 18. Бүх нийтийн хог цэвэрлэгээ*






18/08/2024 11:07
259° W
хог цэвэрлэгээ


18/08/2024 12:26
42° NE
хог цэвэрлэгээ






18/08/2024 11:20
353° N
хог цэвэрлэгээ


KIA MOTORS

# 7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

## 7.1 Агаарын хяналт шинжилгээний дүн

Талбайн агаарын чанарын хэмжилт гүйцэтгэх явцад уртын ачаа тээвэр зогссон байдалтай байсан бөгөөд богины ачаа тээврийн хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй үед гадаад орчинд агаарын мониторингийг гүйцэтгэв.

*Хүснэгт 8. Хэмжилтийн үр дүн*

| Хэмжилтйн цэгийн байршил | Үзүүлэлтийн нэр | Хугацаа /мин/ | Хэмжих нэгж | Стандарт утга | Хэмжигдсэн утга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Авто пүү, нүүрс ачиж буулгах цэгийн орчимд | PM 10 | 10 мин | мкг/м$^3$ | 0-50 | 23 | Уртын болон богины ачаа тээвэргүй үеийн хэмжилтийн үр дүн |
| | PM 2.5 | 10 мин | мкг/м$^3$ | 0-35 | 12 | |
| | Агаарын чийгшил | 10 мин | мкг/м$^3$ | 30-60 | 65 | |
| | Дуу чимээ | 10 мин | дБа | 45-60 | 52 | |
| | Салхины хурд | 10 мин | м/сек | | 2-3 | |
| | Агаарын температур | 10 мин | T$^0$ | | 25 | |
| | TVOC | 10 мин | | | 9.6 | |
| | HCHO | 10 мин | | | 0 | |

Дээрх хэмжилтээс дүгнэвэл уртын болон богины тээвэр зэрэг явагдаж байгаа үед тоосжилтын төвшин өндөр, агаарын чанарын эльментүүд бүгд стандартаас давхаар үзүүлэлттэй гарч байна.

Иймд доор дурьдсан арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллах хэрэгтэй.

- Гадаад орчинд ажиллаж буй ажилтан бүрт амьсгал хамгаалах хэрэгслийг тогтмол зүүж, хэвшүүлэх
- Тоосжилт дарах усалгааг нэмэгдүүлэх, тусгай бодис турших, үйл ажиллагаандаа ашиглах
- Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед 20 сек-ийн дүрмийг мөрдүүлэх
- Явган зорчих хэсгийг бетон хучилттай болгох
- Агаарын хэмжилтийг суурин хийж гүйцэтгэх
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг болно.

## 7.2 Усны хяналт, шинжилгээний дүн

Ханги НАБТ, Дорноговь аймаг, Хатанбулагийн гүний худгийн усны дээжийг “Инженер геодези” ХХК итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

*Хүснэгт 9. Усны дээжний үзүүлэлт*

| Катион | 1 дм$^3$ | | | Анион | 1 дм$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Мг/л | Мг-экв/л | Мг-экв% | | Мг/л | Мг-экв/л | Мг-экв% |
| $Cl^-$ | 1974.57 | 55.62 | 89.68 | $Na^++K^+$ | 837.19 | 36.40 | 58.69 |
| $SO_4^-$ | 151.56 | 3.16 | 5.09 | $NH_4^+$ | 0.10 | 0.01 | 0.01 |
| $NO_3^-$ | 2.06 | 0.003 | 0.05 | $Ca^{2+}$ | 140.28 | 7.00 | 11.29 |
| $NO_2^-$ | 0.50 | 0.01 | 0.02 | $Mg^{2+}$ | 226.18 | 18.60 | 29.99 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 0.03 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| $HCO_3^-$ | 195.26 | 3.20 | 5.16 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | - |
| Дүн | 2323.95 | 62.02 | 100.00 | Дүн | 2314.00 | 62.02 | 100.00 |

*Урвалын орчин pH- 8.16, булингаргүй, тунгалаг, өнгөгүй, үнэргүй MNS0900:2019-д химийн бүрэлдэхүүнээрээ Сульфатын анги, магнийн бүлэг, 3 төрлийн давсархаг буюу их эрдэсжилтэй, маш хатуу ус байв.*

*Хүснэгт 10. Усны дээжний үзүүлэлт*

| № | Ус | Нянгийн тоо | Гэдэсний савханцарын титр(E.coli) | Анаэробын (Cl.perfringens) |
|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу |
| 1 | НАБТ | 2 | Илрээгүй | Илрээгүй |

НАБТ орчмын уснаас авсан дээжийн шинжилгээгээр сульфат, натри, магни, кальцийн хэмжээ тус бүр Монгол улсын ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын MNS0900:2018- стандартын шаардлагыг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээнд хэрэглэвэл аюулгүй болно. Химийн бүрэлдэхүүнээрээ: Сульфатын анги, натрийн бүлэг, 3 төрлийн давстай буюу шорвогдуу, маш хатуу ус бөгөөд зайлшгүй унданд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.

### 7.3 Хөрсний хяналт, шинжилгээний дүн

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн дагуух Гаалийн хяналтын талбайн, ажилчдын кемп хотхон нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд байрлах бөгөөд нийт 4 цэгээс хөрсний зүсэлт морфологи бичиглэл болон дээжийг аван 1 худгаас усны дээжүүдийг тус тус авсан болно.

*Хүснэгт 11. НАБТ-н дээж авсан цэгүүдийн мэдээлэл*

| Цэгийн дугаар | Хөрсний зүсэлт | Уртраг | | | Өргөрөг | | | Хөрсний механик бүрэлдэхүүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | градус | минут | секунд | градус | минут | секунд | |
| 1 |  | 109 | 57 | 24.7 | 42 | 42 | 27.9 | Шавранцар |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 |  | 109 | 57 | 25.0 | 42 | 42 | 27.4 | Шавранцар |
| 3 |  | 109 | 56 | 56.2 | 42 | 42 | 47.7 | Элс |
| 4 |  | 109 | 57 | 26.3 | 42 | 42 | 43.7 | Шавранцар элс |

Хөрсний морфологи бичиглэлийг хээрийн нөхцөлд тодорхойлж, хөрсний үе давхарга бүрээс лабораторийн задлан шинжилгээнд зориулан 4 ш хөрсний дээж авсан. Хөрсийн дээжийн химиi, физик үзүүлэлтийг “Инженер геодези” ХХК-ний хөрсний лабораторид тодорхойлсон.

*Хүснэгт 12. НАБТ орчмын хөрсний химийн үзүүлэлт*

| **№** | **Лаб №** | **Гүн, см** | **pH** | **Давс %** | **Cond, dsm** | **Ялзмаг, %** | **$CaCO_3$, %** | **NO3 Мг/100г** | **Солилцох суурь, мг-экв/100 гр** | | **Шим тэжээлийн элементүүд мг/100гр** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **$Ca^{+2}$** | **Mg** | **$P_2O_5$** | **$K_2O$** |
| **Дээж-1/N 42°42'27.9" E 109°57'24.7"/** | | | | | | | | | | | | |
| 1 | 24/5740 | 0-20 | 8.93 | 0.06 | 0.124 | 0.28 | 0.11 | 1.98 | 9.5 | 5.6 | 1.3 | 22 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 24/6573 | | 9.43 | 0.04 | 0.087 | 0.18 | 0.11 | 1.98 | 8.6 | 5.4 | 0.8 | 22 |
| **Дээж-2/N 42°42'27.4" E 109°57'25.0"/** | | | | | | | | | | | | |
| 2 | 24/5741 | 0-20 | 8.79 | 0.05 | 0.108 | 0.13 | 0.05 | 0.32 | 6.8 | 4.8 | 1.3 | 14 |
| | 24/6574 | | 8.24 | 0.06 | 0.124 | 0.28 | 0.11 | 1.98 | 9.5 | 5.6 | 1.3 | 26 |
| **Дээж-3/N 42°42'47.7" E 109°56'56.0"/** | | | | | | | | | | | | |
| 3 | 24/5742 | 0-20 | 8.82 | 0.04 | 0.098 | 0.25 | 0.11 | 0.32 | 7.2 | 6.0 | 1.1 | 12 |
| | 24/6575 | | 9.33 | 0.02 | 0.056 | 0.16 | 0.07 | 0.32 | 7.2 | 6.4 | 0.4 | 14 |
| **Дээж-4/N 42°42'43.7" E 109°57'26.3"/** | | | | | | | | | | | | |
| 4 | 24/5743 | 0-20 | 8.95 | 0.05 | 0.116 | 0.31 | 0.12 | 0.66 | 8.8 | 7.4 | 1.4 | 28 |
| | 24/6576 | | 8.82 | 0.04 | 0.116 | 0.25 | 0.11 | 0.32 | 7.2 | 6.0 | 1.1 | 12 |

Гаалийн хяналтын талбай болон ажилчдын кемп орчмын талбайгаас 0-20 см гүнд хөрсний дээж авахад талбайн орчимд цөлөрхөг хээрийн /ердийн/ бор хөрс тархсан. Хөрсний тархалтаар урвалын орчин нь/PH/ 8.37-8,97 ба хамгийн түгээмэл тархсан маш хүчтэй шүлтлэгийн орчинтой. Шүлтлэг хөрсүүд суурь катионуудаар (K+, Ca2+, Mg2+ and Na+) ханасан байдал өндөртэй . Ийм хөрсүүдийг уусах давсын агууламжаар нь бага зэргийн давсжилттай, цахилгаан дамжуулах чанар багтай шүлтлэг хөрс юм. Шүлтлэг хөрсүүд карбонатуудыг агуулдаг.

*Хүснэгт 13. НАБТ хөрсний механик бүрэлдэхүүн*

| № | Лаб № | Гүн, см | Механик ширхэгүүд, % Ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Дээж-1/N 42°42'27.9" E 109°57'24.7"/ | | | | | | | | | |
| 1 | 24/5740 | 0-20 | 27.0 | 53.0 | 5.3 | 3.6 | 6.9 | 4.3 | 14.7 |
| | 24/6573 | | 27.1 | 50.9 | 7.7 | 3.4 | 8.0 | 3.0 | 14.3 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дээж-2/N 42°42'27.4" E 109°57'25.0" | | | | | | | | | |
| 2 | 24/5741 | 0-20 | 16.4 | 67.0 | 5.1 | 5.0 | 4.2 | 2.2 | 11.4 |
| | 24/6574 | | 27.0 | 53.0 | 5.3 | 3.6 | 6.9 | 4.3 | 14.7 |
| Дээж-3/N 42°42'47.7" E 109°56'56.0"/ | | | | | | | | | |
| 3 | 24/5742 | 0-20 | 24.2 | 60.2 | 4.5 | 5.0 | 4.6 | 1.4 | 11.1 |
| | 24/6575 | | 21.6 | 61.4 | 3.8 | 4.7 | 5.1 | 3.3 | 13.1 |
| Дээж-4/N 42°42'43.7" E 109°57'26.3"/ | | | | | | | | | |
| 4 | 24/5743 | 0-20 | 15.2 | 64.0 | 7.0 | 2.7 | 4.6 | 6.4 | 13.7 |
| | 24/6576 | | 15.2 | 62.0 | 4.5 | 5.0 | 4.6 | 1.4 | 11.1 |

Качинскийн ангиллаар хөрсний механик бүрэлдэхүүний хувьд шавар, физик элс 2 харьцаагаар, 0.01мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээгээр элс, шавранцар, лаг ба дээжүүдийн ихэнх хэсэг нь элсэрхэг механик бүрэлдэхүүнтэйг илтгэх бөгөөд элсэрхэг элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нэлээд их талбай эзэлж байна.

*Хүснэгт 14. Хөрсний хүнд металл*

| Дээжний дугаар | Он сар өдөр | Дээж авсан гүн, см | Хүнд металлын агууламж мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Ni /Никель/** | **Cd /Кадми/** | **Pb /Хар тугалга/** | **Zn /Цайр/** | **Cr /Хром/** | **Cu /Зэс/** |
| Дээж -1 | 2024.10.28 | 0-20 | 3.90 | - | 8.34 | 50.22 | 2.54 | - |
| | 2024.11.19 | | 22.28 | - | 9.41 | 61.60 | 24.73 | 10.62 |
| Дээж-2 | 2024.10.28 | 0-20 | - | - | 5.92 | 30.51 | - | 1.58 |
| | 2024.11.19 | | 3.90 | - | 8.34 | 50.22 | - | 2.54 |
| Дээж-3 | 2024.10.28 | 0-20 | 29.33 | - | 14.04 | 71.22 | 49.78 | 11.89 |
| | 2024.11.19 | | 15.50 | - | 3.54 | 67.41 | 11.76 | 7.20 |
| Дээж-4 | 2024.10.28 | 0-20 | 56.86 | - | 19.85 | 82.26 | 93.57 | 17.22 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2024.11.19 | | 56.86 | - | 14.04 | 71.22 | 49.78 | 11.89 |
| | **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019** | | | | | | | |
| | **Элсэрхэг хөрс** | | **60** | **1** | **50** | **100** | **60** | **60** |
| | **Шавранцар хөрс** | | **100** | **1.5** | **70** | **150** | **100** | **80** |
| | **Шаварлаг хөрс** | | **150** | **3** | **100** | **300** | **150** | **100** |

Гаалийн хяналтын талбай болон ажилчдын кемп орчмын хөрснөөс авсан 4 дээжийн хүнд металлын шинжилгээ нь 6 төрлийн химийн хүнд металл болох никель, кадми, хар тугалга, цайр, хром болон зэс нь MNS5850:2019 стандартын элсэрхэг хөрсөнд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй тул бохирдолгүй болно.

## 8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Тухайн төслийн 2024 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө нийт 13 бүлэг 98 заалттайгаар БОАЖЯ-ны ХБОБЗГ-аар батлагдсан.
- БОАЖС-ын 2021 оны 7-р сарын 9-ний өдрийн 01/3144 дугаар бүхий ай савын лавлагаатай
- Дорноговь аймгийн БОАЖГ-н 2024 оны 04-р сарын 08-ны өдрийн 148 дугаартай ус ашиглах дүгнэлт
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын 2024 оны 04-р сарын 17-ны өдрийн А/58 дугаартай ус ашиглах зөвшөөрөл
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргатай байгуулсан 2024 оны 04-р сарын 17-ны өдрийн ус ашиглах гэрээ
- Байгаль орчны дотоод аудитыг 5 удаа хийж гарсан зөрчилүүдийг арилгах заавар зөвлөмжийг өгч ажилласан.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын 2023 оны 10-р сарын 4-ний өдрийн А/172 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэгийн зөвшөөрөлтэй.
- 2023 оны 1-р сарын 23-ны өдөр баталгаажсан LXLG-40 загварын 16м3/ц хэмжилтийн хязгаартай, 40 мм голчтой, 202000311 дугаартай, 047 дугаар бүхий лацтай тоолуурыг 2023 оны 1-р сарын 26-ны өдөр суурилуулсан.
- Төслийн хэмжээнд дагаж мөрдөх шаардлагатай 6 байгаль орчны зөвлөмж жагсаалтыг тодорхойлсон.
- Байгаль орчны мэргэжлийн байгууллагын зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг “Мон газар экологи” ХХК-тай хамтран гүйцэтгэхээр төлөвлөсөн.
- 2024 оны төслийн ус ашиглалтын тайланг хүргүүлсэн.
- Нэгтгэсэн БОМТ тайланг хүргүүлсэн.
- БОМТ-2024 нийт төсөв **156 сая.**
- Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг төслийн дотоод орчинд ажилчдын дунд зохион байгуулан ажиллалаа.

## 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой асуудлаар удирдлагын багаас төрийн байгууллагууд болон орон нутгийн малчин ард иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа.

### 9.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлт

- Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Агаар орчныг хамгаалах чиглэлд 9 заалт бүхий ажлыг **89%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Усны нөөц болон чанарыг хамгаалах чиглэлд 12 заалт бүхий ажлыг **90%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Хөрс хамгаалах чиглэлд 12 заалт бүхий ажлыг **83%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

- Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Газар, түүний хэвлийг хамгаалах чиглэлд 3 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлд 7 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн чиглэлд 2 заалт бүхий ажлыг **70%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Түүх соёлын өвийг хамгаалах чиглэлд төлөвлөл байхгүй байсан хэдий ч түүх, соёлын өвтэй холбоотой зурагт постеруудыг бэлтгэн шаардлагатай газруудад байршуулан 100% тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Осол эрсдэлийн менежментийн чиглэлд 8 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Хог хаягдлын менежментийн чиглэлд 6 заалт бүхий ажлыг **91%** тай хэрэгжүүлэн ажиллалаа
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын чиглэлд 7 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.
- Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын ажлын чиглэлд 13 заалт бүхий ажлыг **94%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

### 9.2 Ерөнхий дүгнэлт

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ,АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” төслийн 2024 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт **91%** байна

## ХАВСРАЛТУУД

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр.
Утас: 26 19 66. Факс: (976-51) 26 61 71.
И-мэйл: contact@mne.gov.mn. Вэбсайт: www.mne.mn

2021.07.09 № 01/3144

танай ____________-ны №____________-т

ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК-Д

Лавлагаа хүргүүлэх тухай

Ханги ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбайд ашиглах гүний худгийн цооног нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны 289 дугаар тогтоолоор баталсан Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай тус тус давхцалгүй байна.

Тус гүний худгийн цооног нь "Галба – Өөш – Долоодын говь"-ын сав газарт хамаарагдаж байна.

Зурган мэдээллийг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

Н.УРТНАСАН

000752

...ГАЛЬ ОРЧИН,
...АЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

# ЛАВЛАГАА

Ханги ажилчдын хотхон автобааз гаалийн хяналтын талбайн гүний худаг




| № | xg | xm | xs | yg | ym | ys |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 109 | 57 | 18.9 | 42 | 42 | 22.5 |

**Таних тэмдэг**

- лиценз
- эргэлтийн цэг

**Гадаргын ус**

- Булаг /2012 оны тооллого/
- Гол
- Түр урсацтай гол
- Нуур
  - Байнгын
  - Ширгэдэг

**Засаг захиргааны хил**

- Аймгийн төв
- Сумын төв
- Сумын хил
- Аймгийн хил

**Улсын ТХГН -ийн сүлжээ**

- Тусгай хамгаалалттай газар
- Хориглолтын бүс
- Хязгаарлалтын бүс
- Таамаглалын муж

Худгийн цооног

**Х[illegible]ын бүсүүд**
**Засгийн газ[illegible] болон 289-р тогтоол**

- Голын хамгаалалтын бүсийн хил (Усны тухай хууль 22.3-т 200 метр)
- Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хил
- Голын хамгаалалтын бүс (Усны тухай хууль 22.1-т 50 метр)
- Ойн сан бүхий газар

МАСШТАБ1:250,000

**ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**

**Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэс**

Ханги ажилчдын хотхон автобааз гаалийн хяналтын талбайн гүний худаг нь

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.3, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2.1-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, Ойн сан бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны 289 дугаар тогтоолын Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай тус тус давхцалгүй байна.

Тус гүний худаг нь "Галба-Өөш-Долоодын говь"-ын сав газарт хамаарагдаж байна.

Боловсруулсан: мэргэжилтэн Э.Эрдэнэхүү / /

Огноо: 7/8/2021

2

ДОРНОГОВЬ АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН,**
**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mne.gov.mn
Цахим хаяг: www.do.mine.gov.mn

2024.04.08 № 148

танай ____________-ны №____________-т

"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЛАЙ ЖЭНЬБАО
ТАНАА

Танай ирүүлсэн 2024 оны Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон бусад ирүүлсэн материалыг үндэслэн 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт .... хуудастай.

Хувийг Аймгийн Татварын хэлтэс, Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газарт

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХЗОРИГ

4424030215

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 2024 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдөр Дугаар-10 Сайншанд хот

1.Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:
"Тахилт хайрхан транс" ХХК-ийн захирал Лай жэньбао, Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 15-р хороо, Их монгол улсын гудамж, Моннис Бьюлдинг, 9-р давхар, Утас:976-77200990, 80215274, Улсын бүртгэлийн дугаар 9011730029, регистрийн дугаар 6284655

2. Төслийн нэр, байршил:
Дорноговь аймаг Хатанбулаг сумын нутагт байрлах Ханги тээврийн ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбай

3. Төсөл хэрэгжүүлэгч: "Тахилт хайрхан транс" ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,У/: 4408006262

| X | У |
|---|---|
| 109⁰ 57' 18.17" | 42⁰ 42' 19.968" |
| 109⁰ 56' 50.706" | 42⁰ 42' 53.157" |
| 109⁰ 57' 15.651" | 43⁰ 43' 4.552" |
| 109⁰ 57' 43.107" | 42⁰ 42' 31.240" |

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:
Хатанбулаг сумын нутагт байрлах Ханги тээврийн ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбай

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:
2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Нийт 150-250 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:
2024 онд 4250 $м^2$ зам талбайд тоосжилт дарах усалгаа хийх, кемпэд тээврийн жолооч нар түр байрлах, гаалийн хяналтын тайлбай, кемпийн байнгын үйл ажилагааг хангаж ажиллана.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:
Тус сумын төвд өрөмдлөг гүний худаг байдаг ба усны чанар, ундарга сайтай тул энэ районы ахуй хэрэгцээний усны гол эх үүсвэр болдог.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:
Хаягдал бохир усыг хөрсөнд шингээн зайлуулдаг.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

14. Онцгой нөхцөл:

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны зарцуулалтыг
тооцох
Байгаль орчны сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм"-ын дагуу тооцоход
250хүн x 20л/хон x 365хон=1825,0м$^3$/ ажиллах нийт хугацаанд-унд ахуйн усны хэрэгцээ
4250м$^2$ x 2л/м$^2$ x 1удаа/хон x 365 хон =3102.5 м$^3$ зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус
150мод x 45л/хон x 112 удаа = 756.0м$^3$/жилд - ногоон байгууламжийн усалгаанд ашиглах
Нийт ашиглах усны хэмжээ: 1825,0м$^3$+3102,5м$^3$+756.0м$^3$ =5683,5м$^3$ ажиллах нийт хугацаанд

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:
"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуулийн 20.1.1-д заасны дагуу ажиллагсдын унд- ахуйд ашиглах 1825,0м$^3$ усыг төлбөрөөс чөлөөлнө.
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах 3102,5 м$^3$, Ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 756.0м$^3$ нийт газрын доорх усны төлбөрийн хэмжээг "Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Галба-Өөш Долоодын говийн сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор тогтоосон ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1-р хавсралтын 4,10-д заасан заасан усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг үндэслэн тооцож, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг "Төсвийн тухай" хуулийн 23.6.5-д заасны дагуу аймгийн Төрийн сангийн 060000-944 тоот дансанд төвлөрүүлэх;
Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны төлбөрийг тооцвол:
1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м$^3$ x 0.20 x 0.25=199.8 төг/м$^3$ байна.

- 3996төг/м$^3$- "Галба-Өөш Долоодын говийн сав газар"-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 20хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 4-д заасан хувь хэмжээ.
- 0.25- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу зам талбайн тоосжилт дарахад хийх газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

3102.5м$^3$ x 199.8 төг/м$^3$=619879,5 төг /зургаан зуун арван есөн мянга найман зуун далан есөн төгрөг таван мөнгө/
1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м$^3$ x 0.10 x 0.18=72.0төг/м$^3$

- "Галба-Өөш Долоодын говийн сав газар"-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3996 төг/м$^3$ байна.
- 10 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь хэмжээ.
- 0.18- ашиглах усны ашиглалтын зориулалтын итгэлцүүр
- 756.0м$^3$ жилд – ногоон байгууламжийн усалгаа

756.0м$^3$ x 72.0төг=54432.0 төг /тавин дөрвөн мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг /
Нийт: 54432.0 төг + 619879.5 төг = 674311,5 төг /зургаан зуун далан дөрвөн мянга гурван зуун арван нэгэн төгрөг таван мөнгө /

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Хатанбулаг сумын Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах /"Усны тухай" хуулийн 28.6-р зүйл/
- Усны шинжилгээг хийлгэж дүнг ирүүлэх
- "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мөрдөн ажиллах /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаал/
- "Аж ахуйн нэгжийн экологийн паспорт" хөтлөх /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Стандартчилал хэмжилзүйн хэлтсээс авах/
- Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч ажиллах /Усны тухай хуулийн 31.2-р зүйл/
- Байгаль орчны менежментын төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх
- Ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Хатанбулаг сумын Төрийн сан банкны дансанд тушааж хуулбар хувийг ирүүлэх /Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжын тухай" хуулийн 21.1, 20-р зүйл, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 51-р тогтоол/
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс болох 50 000 төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Төрийн сан банкны 100 060013001 дансанд тушаах /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-376 тоот тушаал/
- Зөвлөмжид заасан ажлын тайлан, Ус ашиглалтын мэдээ тайланг 12-р сарын 05-нд багтаан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН: Ш. АМГАЛАНСАЙХАН

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: С. ЭНХЗОРИГ

ДОРНОГОВЬ АЙМАГ
**ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 17 өдөр                Дугаар А/58                Аман-Ус

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.11 дэх заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дүгээр тушаал, Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын "Ус ашиглуулах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Ханги боомтод байрлах ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбайд кемпийн байнгын үйл ажиллагаа явуулах XV-4408006262 тусгай зөвшөөрөл бүхий "Тахилт хайрхан транс" ХХК-ний унд ахуй, зам талбайн тоосжилт дарах ажилд зориулан 3 дугаар багийн нутаг дахь Ханги боомтод байрлах "Тахилт хайрхан транс" ХХК-ийн концессын замын дагуух гүний худгаас авах 5683.5м$^3$ ус авч ашиглахыг зөвшөөрсүгэй.

2.Ус ашиглагч "Тахилт хайрхан транс" ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулан холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөж хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Цэцэгсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч  (Г.Ганмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА                С.ЭРДЭНЭБОЛД

442402141

БАТЛАВ.

ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.ЭРДЭНЭБОЛД

БАТЛАВ.

"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК – НЫ ЗАХИРАЛ

ЛАЙ ЖЭНЬ БАО

# УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 04 сарын 17-ны өдөр Дугаар ..... Хатанбулаг сум

## Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар ус ашиглуулах дүгнэлт, Хатанбулаг сумын Засаг даргын 2024 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн А/58 дугаар тушаалыг тус тус үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын дарга Т. Цэцэгсүрэн нөгөө талаас ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Их Монгол улсын гудамж, Моннис бьюлдинг, 6-р давхар "Тахилт хайрхан транс" ХХК, улсын бүртгэлийн дугаар 9011730029, регистрийн дугаар 6284655, байгаль орчны ахлах мэргэжилтэн Б.Лхагважаргал нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулав.

## Хоёр. Гэрээний гол нөхцөл

**2.1. Ус ашиглах зориулалт:**

- 2.1.1. Унд ахуйн хэрэгцээний ус
- 2.1.2. Гаалийн хяналтын талбайн зам талбайн тоосжилтыг дарах усалгаа хийх

**2.2. Ашиглах усны хэмжээ:**

- 2.2.1. Унд ахуйн хэрэгцээний ус – 1825,0 м$^3$/жил
- 2.2.2. Зам талбайн тоосжилтыг дарахад ашиглах ус - 3102,5м$^3$/жил
- 2.2.3. Ногоон байгууламжийн усалгаанд ашиглах ус – 756,0м$^3$/жил

**2.3. Усны эх үүсвэрийн мэдээлэл:**

| Худгийн дугаар | Уртраг | Өргөрөг | Ундарга, л/сек | Насосны марк | Тоолуурын марк |
|---|---|---|---|---|---|
| Хатанбулаг Ханги гаалийн хяналтын талбай | 109°57'18.9" | 42°42'22.5" | 1,5 | Power-6000 | LXL-6 |

**2.4. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:**

**Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм”-ын дагуу тооцооход**

250хүн x 20л/хон x 365 хон = 1825,5м$^3$ – Хүн амын унд ахуйн усны хэрэгцээ

4250м$^2$ x 2л/м$^2$ x 1удаа/хон x 365 хон = 3102,5м$^3$ – Зам талбайн тоосжилт дарах ус

150 мод x 45л/хон x 112 удаа = 756,0м$^3$ - Ногоон байгууламжийн услалгаа

**Нийт ашиглах усны хэмжээ : 1825,5м$^3$ + 3102,5м$^3$ + 756,0м$^3$ = 5683,5м$^3$**

2.4.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын дагуу хүн амын унд ахуйн жилд ашиглах **1825,5 м$^3$** усыг төлбөрөөс чөлөөлнө.

2.4.2 Тоосжилтыг дарах зам талбайн услагаанд ашиглах усны төлбөр:
**<u>1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр – 3,996 төг/м$^3$ x 0.2 x 0.25 = 199.8 төг/м$^3$</u>**

- *3,996 төг/м$^3$ – “Галба-Өөш долоодын сав газар”-т газрын доорх усны нөөц ашигласны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ*
- *20% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 4-д заасан хувь хэмжээ*
- *0.25 – Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу эрэл, хайгуулын өрөмдлөг хийх газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр*

2.4.3. **<u>1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр – 3,996 төг/м$^3$ x 0.10 x 0.18 = 72.0 төг/м$^3$</u>**

- *3,996 төг/м$^3$ – “Галба-Өөш долоодын сав газар”-т газрын доорх усны нөөц ашигласны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ*
- *10% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь хэмжээ*
- *0.18 – Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ногоон байгууламжийн услалгааны зориулалтыг тооцох итгэлцүүр*

**Нийт төсөвт төвлөрүүлэх төлбөр:**

**3102,5 м$^3$ * 199.8 төг/м$^3$ + 756,0 м$^3$ * 72.0 төг/м$^3$ = 674,311 төгрөг /*Зургаан зуун далан дөрвөн мянга, гурван зуун арван нэг*** / төгрөгийг 2024 оны 12 сарын 25-ны дотор төвлөрүүлнэ үү.

2.5 Энэхүү гэрээний 2.4.2-т заасан төлбөрийг ус ашиглагч нь усны тухай хуулийн 30.1.4 заалтын дагуу усны эх үүсвэрийг гүний худагыг тоолууржуулан баталгаажуулж тоолуурын заалтаар төлбөрийг төлнө.

2.6 “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 23.2.-т заасны дагуу төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг татварын албанд тушааж эцсийн байдлаар тооцоо хийнэ.

2.7 Дүгнэлт зөвшөөрөлд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан тохиолдолд илүү ашигласан усны төлбөрийг Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолын дагуу шатлан өсгөж тооцно.

**Гурав. Талуудын эрх, үүрэг**

3.1. Гэрээ байгуулагч талууд Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 17.1.10, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-т заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Гэрээний хоёр талт зорилтыг хангах зорилгоор Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ ба Ус ашиглагч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэх бүх арга хэмжээг авч хамтран ажиллана.

## Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг 2024 оны 12-р сарын 20-ны дотор Хатанбулаг суманд хүргүүлэх бөгөөд талууд 2025 оны 01 дүгээр сард багтаан гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан;

4.5.3. Гэрээний үүргийг ноцтойгоор зөрчсөн бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Ус ашиглуулагчийг төлөөлж:**
Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын дарга
Т.Цэцэгсүрэн
Хаяг: Дорноговь аймаг
Хатанбулаг сум
Харилцах утас: 88105434

**Ус ашиглагчийг төлөөлж:**
"Тахилт хайрхан транс" ХХК-ны байгаль орчны ахлах мэргэжилтэн
Б. Лхагважаргал
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Их Монгол улсын гудамж, Моннис бьюлдинг, 6-р давхар
Харилцах утас: 99076875

# УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН
2004 ОНЫ 185 ТООТ
ТУШААЛААР БАТЛАВ.

# ӨРӨМДМӨЛ ХУДГИЙН ТЕХНИКИЙН ПАСПОРТ

ЭНЭХҮҮ ПАСПОРТЫГ ХУДАГ ЭЗЭМШИГЧ ӨМЧИЛНӨ

## Паспортыг хөтлөх журам

1. Паспортыг эхлээд анхааралтай уншиж судал

2. Ашиглалтанд хүлээж авсан өрөмдмөл худаг нь эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэгдэх тусгай зориулалттай байгууламж учир худгийг гаргасантай болон ашиглалттай холбогдсон явцыг харуулсан техникийн паспорт байна.

3. Өрөмдмөл худгийн паспортын анхны бичилтийг худаг гаргасан аж ахуйн нэгж хийж аймаг, нийслэлийн Байгаль орчны албаар баталгаажуулан худаг эзэмшигчид хүлээлгэн өгнө. Паспортыг худаг гаргаж, шавхалт туршилт хийж, ашиглах боломжтой болгож ашиглалтад хүлээж авсан үеэс эхлэн хөтөлнө.

4. Худаг эзэмшигч нь худгаас гарган авч буй усны хэмжээг (насосыг) ажиллуулах бүрт тодорхойлж, улирал бүрээр тэмдэглэлийг үнэн зөв хөтөлнө.

5. Өрөмдмөл худаг бүр мэдээллийн сангийн код болон улсын дугаартай байна. Худгийн код болон улсын дугаарын харъяа аймаг, нийслэлийн Байгаль орчны алба олгоно.

6. Усны барилга байгууламжийн паспортыг уг байгууламжийг эзэмшин ашиглагч иргэн, эсвэл аж ахуйн нэгж байгууллагын усны асуудал хариуцсан албан хаагч хариуцан хадгална.

7. Худгийн усыг борлуулсны орлогыг улирал бүрээр улирлын эцэст нэг удаа бөглөх.

Сум, дүүрэг, хороо........................................................

Эзэмшигч иргэн, байгууллагын нэр "Тахилт хайрхан транс" ХХК

Өрөмдмөл худгийн Ханги - №1

Улсын №

Байршиж буй газрын нэр, хаяг Дорноговь аймгийн Хатанбулаг сум Ханги боомт

Ус ашиглах гэрээний №

Ус ашиглах эрхийн бичгийн №

Худаг гаргасан (аж ахуйн нэгж) "Дорж дриллинг" ХХК

ДОРЖ ДРИЛЛИНГ ХХК DD DORJ DRILLING LLC 1118273 8362354 УЛААНБААТАР ХОТ

Захирал Х. Цовоодорж

2020 он 09 сар 01 өдөр

Баталгаажуулсан.

....................аймаг (нийслэл)-ын Байгаль орчны албаны

тамга

Дарга..............................

20 ... он ... сар .... өдөр

## Худгийн байршлын солбицол

**Уртраг:** 109°57'18,9"

**Өргөрөг:** 42°42'22,5

**Үнэмлэхүй өндөр:** 1154 м,

| Аймгийн код | Сумын код | Худгийн зориулалтын код |
|---|---|---|
| | | |

Дорноговь аймгийн, хотын Хатанбулаг сумын дүүргийн, хорооны, багшийн 4 баг Ханги гэдэг газарт, ундны ус -д зориулан Улаанбаатар аймгийн, (хотын) "Дорж дриллинг" компаний Жаргалсайхан менежер ахлагчтай анги, бригад Power-6000, маркийн станокоор усан эргэлт, хийн цохилт аргаар Уул худгийн цооногийг 20 20 он 07 сарын 23 өдрөөс 20 20 он 08 сарын 07 өдөр хүртэл өрөмдөж гаргав.

## I. ЦООНОГИЙН БҮТЭЦ ЗОХИОМЖ

1. Цооногийн гүн ....200.... м
2. Усны тогтсон түвшин (статик) ....38,33.... м
3. Цооногийн ашиглалтын усны ундарга ....1,0.... м
4. Цооногийн өрөмдсөн диаметр

   ....0,0.... м-ээс ....200.... м хүртэл ....150,3.... мм

   ....–.... м-ээс ....–.... м хүртэл ....–.... мм

   ....–.... м-ээс ....–.... м хүртэл ....–.... мм

5. Уст үеийн байрлал:

   Нэгдүгээр үе ....63,0.... м-ээс ....66,0.... м

   Хоёрдугаар үе ....112,0.... м-ээс ....120,0.... м

   Гуравдугаар үе ....–.... м-ээс ....–.... м

6. Цооногийн бэхэлсэн суултын яндан

   диаметр....159....мм ....0,0.... м-ээс ....43,0.... м

   диаметр....–....мм ....–.... м-ээс ....–.... м

   диаметр....–....мм ....–....м-ээс ....–.... м

7. Шүүрийн хийц зохиож:

   Шүүрийн яндагийн нүхний диаметр ....1,0.... мм

   1 уртааш м-т оногдох нүхний тоо ....15,0....ширхэг

   Шүүрийн диаметр ....Ø100,0.... мм

   Шүүрийг ороосон утасны диаметр ....–....мм

   Шүүрийг ороосон торны ....–....

   Шүүрийн яндангийн нийт урт ....120,0.... м



Үүнд:

Шүүрийн дээд хэсгийн урт....120....м ....60,0.... м-ээс ....180,0.... м

Ажлын хэсгийн урт ....120.... м ....60,0.... м-ээс ....180,0.... м

Дүлий хэсгийн урт....60,0....м ....0,0.... м-ээс ....60,0.... м

Ажлын хэсгийн урт....120....м ....60,0.... м-ээс ....180,0.... м

Дүлий хэсгийн урт ....20,0....м ....180,0.... м-ээс ....200,0.... м

Тунгаагчийн урт....20,0....м ....180,0.... м-ээс ....200,0.... м

8. Яндагийн араар дүүргэсэн хайрга

9. Цооногт ....–.... м-ээс ....–.... м хүртэл

....–.... м-ээс .......... м

хүртэл

Цементац (тампонаж) хийв.

10. Шавхалтыг 20.20 он ..08.. сарын ..06.. өдрийн ..12.. цагаас......

..08..сарын ..07..өдрийн ....12.....цаг хүртэл ....24.....цаг хийв.

Шавхалтыг ..ЭЦ100.. маркын насосаар ....150....м

гүнд насосыг суулгаж.........–......... маркын

компрессороор ....–....м ус өргүүр яндангг ....–.... м

гүнд суулгаж ....–....м хий дамжуулах яндангг....–.... м

усны түвшин хэмжигч яндангг.........–......... м

гүнд тус тус суулгаж гүйцэтгэв.

Шавхалт хийхэд усны

I. Түвшин бууралт....38,3....метр ундарга ....1,5....л/с

II. Түвшин бууралт....66,2....метр ундарга ....1,2....л/с

III. Түвшин бууралт....81,0....метр ундарга ....1,0....л/с

тус тус байв.

## II. ЦООНОГИЙН ЗҮСЭЛТ

| Масштаб см:м | Үеийн ул хүртэлх гүн (м) | Геологийн зүсэлт | Чулуулгийн бичлэг, геологийн насны индекс | Хийц зохиомж | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Суултн шүүрийн яндангийн байрлал | Суулгасан гүн, м |
| 1:100 | | | Бор шаргал | | |
| | 20,0 | | шавар нягт, | Ø159мм | |
| | 40,0 | | хайрга дайрга агуулсан | | |
| | 60,0 | | Цайвар саарал | | |
| | | | шохойн чулуу хэврэг [illegible] | | |
| | 80,0 | | | [illegible] | |
| | | | | | |
| | 100,0 | | Хөх саарал | Ø100мм | |
| | 120,0 | | өнгийн [illegible] | | 120м |
| | 140,0 | | [illegible] ан цавтай | | |
| | | | | | |
| | 160,0 | | | | |
| | 180 | | | | |
| | 200,0 | | Хөх саарал [illegible] [illegible] | | |
| | | | | | |
| | | | | | |



## III. ЦООНОГИЙН ЗҮСЭЛТ

1. Шинжилгээ хийсэн он, сар, өдөр ..........................

| Үзүүлэлтүүд | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|
| | № ........... м | № ........... м | № ........... м |
| Дээж авсан | | | |
| Лабораторт өгсөн | | | |

2. Физикийн шинж чанар:

| Үзүүлэлтүүд | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|
| | № ........... м | № ........... м | № ........... м |
| Өнгө | | | |
| Үнэр | | | |
| Амт | | | |
| Тунгалаг чанар | | | |
| Тунадас | | | |
| Булингар | | | |
| Температур C° | | | |

3. Химийн найрлага:

| Үзүүлэлтүүд | Нэгж хэмжээ | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|---|
| | | № .....м | № ......м | № .... м |
| PH (идэвхит урвал) | | | | |
| $CO^2$ (чөлөөт) | мг/л | | | |
| $CO^2$ (түрэмгий) | " | | | |
| $H^2S$ (хүхэрт устөрөгч) | " | | | |
| $SiO^2$ (Цахиурын хоёрт исэл) | " | | | |
| Исэлдэх чанар $O^2$ | " | | | |
| Хуурай үлдэгдэл 180°C | " | | | |
| Ерөнхий хатуу | мг, экв/л | | | |
| Арилгах хатуу | | | | |
| Тогтмол хатуу | | | | |

| Анионууд | Уст үеийн № ба интервал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | № .....м | | № ......м | | № .......м | |
| | мг/л | мг,экв/л | мг/л | мг,экв/л | мг/л | мг,экв/л |
| Cl | | | | | | |
| $SO_4$ | | | | | | |
| $CO_3$ | | | | | | |
| $HCO_3$ | | | | | | |
| $NO_2$ | | | | | | |
| $NO_3$ | | | | | | |
| | | | | | | |
| Дүн | | | | | | |

| Катионууд | Уст үеийн № ба интервал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | № .....м | | № ......м | | № .......м | |
| | мг/л | мг,экв/л | мг/л | мг,экв/л | мг/л | мг,экв/л |
| (Na+K) | | | | | | |
| $NH_4$ | | | | | | |
| Ca | | | | | | |
| Mg.... | | | | | | |
| Fe.... | | | | | | |
| Fe.... | | | | | | |
| | | | | | | |
| Дүн | | | | | | |



4. Бактериологийн шинжилгээ:

| Уст үеийн № ба интервал | Дээж авсан он, сар, өдөр | Шинжилсэн усны 1см³ дахь нянгийн тоо | Шинжилсэн усны хэмжээ | Коли- индекс |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

5. Усны химийн шинжилгээ хийсэн байгууллага..................
..........................................................................................

6. Усны бактериологийн шинжилгээ хийсэн байгууллага ......................................................
..........................................................................................

7. Усны хими, бактериологийн шинжилгээний дүгнэлт, хүн малын ундаанд хэрэглэж болох эсэх
..........................................................................................
..........................................................................................
